



**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/187

Улаанбаатар хот

**Ажлыг хэсэгт нэмэлт
оруулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.5, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын “Монгол Улсын Үндэсний Фармакопейд үнэлгээ хийх, ажлын хэсэг байгуулах тухай” 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/187 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Үндэсний Фармакопейд үнэлгээ хийх, ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-д Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эм найруулагчийн тэнхимийн ахлах багш, Эм зүйн ухааны доктор П.Мандахнаран, Анагаахын ухааны магистр, клиникийн профессор, зөвлөх зэргийн эмч Т.Алимаа, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн биобэлдмэлийн үйлдвэрийн үйлдвэрлэл хариуцсан менежер, Биологийн ухааны доктор Б.Сайнчимэг нарыг нэмж гишүүнээр ажиллуулсугай.

2. Ажлын хэсгийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, удирдамжийн дагуу ажиллахыг ажлын хэсгийн дарга Эм үйлдвэрлэлийн хэлтэс (Д.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА